



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМАГТ 2023-2024 ОНД НИЙТ 46,630 ЗӨРЧИЛД 2,370.3 САЯ ТӨГРӨГИЙН ТОРГУУЛЬ НОГДУУЛЖ, ҮҮНЭЭС 2,004.2 САЯ ТӨГРӨГ БҮЮУ 84.5 ХУВЬ НЬ УЛС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРСӨН БА ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ ҮЛДЭГДЛИЙН 78.3 ХУВИЙГ ЦАГДААГИЙН ГАЗРЫН НОГДУУЛСАН ТОРГУУЛЬ ЭЗЭЛЖ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ
АУДИТЫН КОД: СБА-2025/27-16-ШТА-ГА

Баруун-Урт хот 2025 он



Газрын дарга, тэргүүлэх аудитор **Г.Даваа**

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер **М.Нарантуяа**

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор **Ө.Золзаяа**

Утас: 70512127 Цахим хаяг: Zolzayau@audit.gov.mn

Аудитор **Г.Оюунболд**

Утас: 70512127 Цахим хаяг: Oyunboldg@audit.gov.mn

Аудитор **О.Барчидгүнсэн**

Утас: 70512127 Цахим хаяг: Barchidgunseno@audit.gov.mn

Аудитор **Б.Мөнхбамбар**

Утас: 70512127 Цахим хаяг: Munkhbambarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ А Хүү, торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.	5
А.1 Хүү, торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөснөөр холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.	5
А.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.	6
А.3 2023, 2024 онуудад 291.8 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.	9
БҮЛЭГ Б Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн байна.	11
Б.1 Торгуулийн орлого төсөвт бүрэн төвлөрөөгүй, төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна.	11
2.1.4.2 Дээрх дүнгээс 13 сумын татварын орлогыг харьцуулж үзэхэд дунджаар 3.3 хувийг хүү торгуулийн орлого эзэлж байгаа бөгөөд хамгийн их нь Түмэнцогт сум 15.2 хувь, хамгийн бага нь Сүхбаатар сум 0.3 хувийг эзэлж байна. Аймгийн ерөнхий орлогын хувьд нийт орлого 37,332.5 сая төгрөг, хүү, торгуулийн орлого 1,755.3 сая төгрөг буюу 4.7 хувь байна.	13
Б.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөрөнгийг хуульд заасны дагуу өмнөх жилийн орлогын гүйцэтгэлээр хуваарилаагүй байна.	13
БҮЛЭГ В Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим хэрэгжүүлсэн ТАХ чанарын шаардлага хангахгүй байна.	15
В.1 Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулжээ.	15
В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлж байна.	17
БҮЛЭГ Г. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж байна уу?	18
Г.1 Улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна.	18
Г.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлж байна уу?	19
Холбогдох байгууллагын санал:	22
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	22
ДҮГНЭЛТ:	22
ЗӨВЛӨМЖ:	23
Үндэсний аудитын газраар уламжлуулан холбогдох төр захиргааны төв байгууллагуудад хүргүүлж буй зөвлөмж:	23

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	НД-ын сангийн харилцахын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	5
Хүснэгт 2	ОНӨҮГ-уудын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	5
Хүснэгт 3	Сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	6
Хүснэгт 4	Сумдын хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	7
Хүснэгт 5	2023-2024 онд ногдуулсан торгуулийн орлого	11-12
Хүснэгт 6	Нийт татварын орлогод эзлэх хувь хэмжээ	12-13
Хүснэгт 7	ГХУС-сангийн 2023, 2024 оны төлөвлөлт	14
Хүснэгт 8	Замын сангаар хийгдсэн ТАХ	15
Хүснэгт 9	Цагдаагийн байгууллагын торгуулийн орлогын төвлөрүүлэлт	19
Хүснэгт 10	Прокурорын байгууллагаас хүчингүй болгосон, өөрчлөлт оруулсан шийдвэрийн тоо	20

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит үндэслэл, эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. • Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх; • Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх; • Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх; • Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын 2023-2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн баримт материал, тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулан гүйцэтгэсэн. Аудитад нийт 27 байгууллага, 206 албан тушаалтны 2023-2024 оны баримт материалыг хамруулан судалгааг авч нэгтгэсэн болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ө.Золзаяа, аудитор Г.Оюунболд, О.Барчидгүнсэн, Б.Мөнхбамбар нар гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТЫН УЯЛДАА ХАНГАГДААГҮЙ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ТОДОРХОЙ БУС БАЙСНААС ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРӨХГҮЙ, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ, ХӨРӨНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН ҮР АШИГ БУУРАХ НӨХЦӨЛ БҮРДСЭН БАЙНА.

А.1 Хүү, торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тогтоосон хувь хэмжээ зэрэг бодит үндэслэлд тулгуурлан төлөвлөснөөр Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг хангах, орлогыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах нөхцөл бүрдэж байна.

А.1.1 Хүүгийн орлогыг тогтоосон хувь хэмжээнд тулгуурлан төлөвлөж байна.

1.1.1.1 Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газар тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, ажилгүйдлийн сангийн дөрвөн дансыг арилжааны банканд байршуулах замаар харилцахын хүүгийн орлогыг төлөвлөж, НДЕГ-ын даргын 2022 оны 06, 2024 оны А/240 дүгээр тушаалаар баталгаажуулсан байна.

Хүснэгт №1. НД-ын сангийн харилцахын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	2023 оны Төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл	2024 оны Төлөвлөгөө	2024 оны Гүйцэтгэл
А	1	2	3	4
2. Харилцахын хүүгийн орлого	48.2	36.3	48.2	45.5

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10.2, 11.1.4, тус хуулийн 12 дугаар зүйл заалтуудтай нийцүүлэн бодит хэрэгцээ шаардлагын дагуу төлөвлөжээ.

1.1.1.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨААТҮГ-ын хүүгийн орлогыг төлөвлөдөггүй бөгөөд дараах байдлаар орлого төвлөрсөн байна.

Хүснэгт №2. ОНӨҮГ-уудын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/

Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Нийт дүн		Үүнээс			
	Төлөвлөлт	Гүйцэтгэл	2023 он		2024 он	
			Төл	Гүй	Төл	Гүй
Сүхбаатар хөгжил үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ	8.2	8.2	8.2	8.2	-	-
Дөрвөлж ОНӨААТҮГ	-	12.0	-	4.2	-	7.8
Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ	-	0.5	-	0.3	-	0.2
Автотээврийн үндэсний төв	-	0.7	-	0.3	-	0.4
Сүхбаатар Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	-	1.0	-	0.1	-	0.9
ДҮН	8.2	22.5	8.2	13.2	-	9.3

1.1.1.3 Сүхбаатар хөгжил үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ нь аймгийн Засаг даргын баталсан журмын дагуу “Цайртминерал” ХХК-аас орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг буюу татварын бус орлогын тодорхой хэсгийг жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжид жилийн 3 хувийн хүүтэй зээл олгож, 2023 онд уг зээлийн хүүгийн орлогыг бүрэн төлөвлөсөн байна.

А.1.2 Торгуулийн орлогыг хууль, журмын хүрээнд төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

1.1.2.1 Сүхбаатар аймгийн орон нутгийн төсөвт Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан торгуулийн орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төлөвлөгөөнд үндэслэн, аймаг болон сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолоор 2023 онд 1,285.0 сая төгрөг, 2024 онд 3,123.0 сая төгрөгөөр тус тус тодотгон төлөвлөж, баталсан байна.

1.1.2.2 Торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төлөвлөснөөр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т заасны дагуу уг орлогын тодорхой хувийг зориулалтын чиглэлээр зарцуулах эрх зүйн болон санхүүгийн үндэслэл бүрдэж, хэрэгжилтийг хангах нөхцөл бий болсон нь бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

1.1.2.3 Торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төлөвлөснөөр, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд уг орлогын тодорхой хувийг зориулалтын дагуу ашиглах эрх зүйн болон санхүүгийн үндэслэл бүрдсэн. Энэ нь хуульд заасан чиг үүргийг санхүүжүүлэх бодит эх үүсвэрийг бүрдүүлж, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, төлөвлөгөөт арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгосон байна. Улмаар замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чиглэсэн санхүүжилт төлөвлөгөөтэй, үр нөлөөтэй, зорилтот байдлаар зарцуулагдах боломжийг хангаж, төрийн үйлчилгээний үр ашиг, иргэдийн аюулгүй байдлыг дээшлүүлэхэд нөлөө үзүүлж байна.

А.2. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлтөд цар тахлын нөлөө байсан ч үндэслэлгүй төлөвлөлтөөс болж тасралт гарсан тул оновчтой, бодитой төлөвлөх шаардлагатай байна.

А.2.1 Өмнөх онуудад торгуулийн орлогын биелэлт нь цар тахлаас шалтгаалан тасрах эрсдэл үүссэн байна.

1.2.1.1 Сүхбаатар аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг 2021 онд 1,072.5 сая, 2022 онд 1,191.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Хүснэгт №3. Сумдын 2021-2022 оны торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/

№	Сумын нэр	2021 он			2022 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан/ Тасарсан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан/ Тасарсан
А	Б	1	2	(3-2)	3	4	(4-3)
1	Асгат	5.0	4.7	-0.3	5.0	3.8	-1.2
2	Баяндэлгэр	18.0	21.7	3.7	20.0	24.6	4.6
3	Дарьганга	30.0	29.2	-0.8	25.0	19.8	-5.2
4	Мөнххаан	46.0	67.5	21.5	60.0	62.7	2.7
5	Наран	2.5	8.6	6.1	8.0	4.8	-3.2
6	Онгон	13.0	21.0	8.0	15.0	8.3	-6.7
7	Түвшинширээ	11.0	9.9	-1.1	6.0	9.1	3.1
8	Түмэнцогт	25.0	49.0	24.0	60.0	60.1	0.1
9	Уулбаян	15.0	7.7	-7.3	10.0	10.4	0.4
10	Халзан	4.0	1.9	-2.1	7.0	0.6	-6.4
11	Эрдэнэцагаан	35.0	34.3	-0.7	35.0	22.8	-12.2

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

12	Баруун-Урт	265.0	347.3	82.3	320.0	335.6	15.6
13	Сүхбаатар	20.0	19.5	-0.6	20.0	14.7	-5.3
14	Аймаг	583.0	852.0	269.0	600.0	330.3	-269.7
	Нийт дүн	1,072.5	1,474.3	401.7	1,191.0	907.6	-283.4

1.2.1.2 Торгуулийн орлогын төлөвлөлт нь өмнөх жилийн гүйцэтгэлд тулгуурладаг тул цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хүндрэл, хөдөлгөөний хязгаарлалтаас шалтгаалан орлого тасрах эрсдэлтэй байсан. Зарим сумдын орлого тасарсан нь бүс нутгийн нөхцөл байдлын ялгаатай байдалтай холбоотой. Үүнээс шалтгаалан аймгийн нийт торгуулийн орлого 2022 онд төлөвлөснөөс 23.8 хувиар буурсан нь төсөвт төвлөрүүлэх орлогын тасалдал үүсгэж, зарим төлөвлөгөөт ажлуудын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй болсон.

1.2.1.3 Иймд торгуулийн орлогыг төлөвлөхдөө зөвхөн өмнөх жилийн гүйцэтгэлд бус, тухайн жилд нөлөөлж болох эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзан үзэж, илүү бодитой, уян хатан төлөвлөлт хийх шаардлагатай байна.

А.2.2 Аймгийн хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө өөдрөгөөр төсөөлсөнтэй холбоотой 60 гаруй хувиар тасарсан тул илүү оновчтой төлөвлөлт шаардлагатай байна.

1.2.2.1 Аймаг, сумдын хэмжээнд хүү, торгуулийн орлогыг дараах байдлаар төлөвлөж батлуулсан байна. Үүнд:

Хүснэгт №4. Сумдын хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/

№	Сумын нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь
1	Аймаг	600.0	1,181.8	197.0	2,240.0	912.1	40.7
2	Асгат	15.0	13.6	90.5	20.0	14.1	70.5
3	Баяндэлгэр	25.0	30.8	123.3	25.0	18.5	74.1
4	Дарьганга	30.0	25.6	85.4	30.0	25.2	83.9
5	Мөнххаан	70.0	82.3	117.5	70.0	84.9	121.3
6	Наран	6.0	1.1	18.7	6.0	2.1	34.2
7	Онгон	10.0	16.6	165.9	15.0	6.5	43.2
8	Түвшинширээ	8.0	6.1	76.7	10.0	4.8	47.5
9	Түмэнцогт	100.0	91.2	91.2	100.0	105.4	105.4
10	Уулбаян	13.0	16.7	128.8	15.0	8.1	54.1
11	Халзан	3.0	3.9	129.1	2.0	4.0	199.4
12	Эрдэнэцагаан	25.0	53.9	215.4	70.0	61.3	87.6
13	Баруун-Урт	360.0	519.2	144.2	500.0	504.6	100.9

14	Сүхбаатар	20.0	16.8	84.1	20.0	3.9	19.5
Нийт дүн		1,285.0	2,059.6	160.3	3,123.0	1,755.3	56.2

1.2.2.2 Аймаг, сумдын хэмжээнд 2023-2024 онд хүү, торгуулийн орлогыг төлөвлөсөн бөгөөд сумдын хувьд орлого харьцангуй тогтвортой буюу төлөвлөгөөнөөс тасралт гаргаагүй байна. Тухайлбал, сумдын гүйцэтгэл 70-215 хувийн хооронд хэлбэлзэж, зарим сумд төлөвлөснөөс давсан орлогыг төвлөрүүлсэн байна.

1.2.2.3 Харин аймгийн төсөвт хүү, торгуулийн орлогод 2023 онд 1,181.8 сая төгрөг төвлөрч байсан бол 2024 онд 2,240.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 912.0 сая төгрөг буюу 1,328.0 сая төгрөгөөр тасарсан нь нийт төлөвлөсөн орлогын 60 гаруй хувийг эзэлж байна.

1.2.2.4 Энэхүү тасралтын гол шалтгаан нь орлогын төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэл, суурь судалгаанд тулгуурлалгүйгээр хэт өөдрөгөөр төлөвлөсөн, мөн төлөвлөлтийн үндэслэл тодорхойгүй байсан явдал гэж дүгнэж байна.

1.2.2.5 Үүний улмаас төсвийн орлого тасрах эрсдэл үүсэж, аймгийн төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө, үүнийг дагасан үйл ажиллагааны төлөвлөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн.

1.2.2.6 Иймд хүү, торгуулийн орлогыг төлөвлөхдөө тухайн жилийн нөхцөл байдал, гүйцэтгэлийн судалгаа, бодит мэдээлэлд тулгуурлан оновчтой, бодитой төлөвлөх шаардлагатайг харуулж байна.

А.2.3 Хүүгийн орлогыг гэрээнд заасан хүүгийн хэмжээ, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.

1.2.3.1 Аймгийн Нийгмийн даатгалын газар НДЕГ-аас арилжааны банкуудтай байгуулсан гэрээний дагуу сангийн үлдэгдэлд ногдох хүүгийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.

1.2.3.2 ОНӨААТҮГ-ын хүүгийн орлого арилжааны банкт байгуулсан гэрээнд заасан хувь хэмжээгээр төвлөрдөг бөгөөд хүүгийн орлогыг урьдчилан төлөвлөдөггүй байна.

1.2.3.3 Харин Сүхбаатар хөгжил үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ нь аймгийн Засаг даргын баталсан журмын хүрээнд “Цайртминерал” ХХК-аас авсан санхүүжилтээр аж ахуйн нэгжид жилийн 3 хувийн хүүтэй ЖДҮ-ийн зээл олгож, 2023 онд зээлийн хүүгийн орлогыг төлөвлөж баталсан байна.

А.2.4 Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолсон байна.

1.2.4.1 Нийгмийн даатгалын газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд хүүгийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолдоггүй, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд зарцуулагдаж байна.

1.2.4.2 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу зөрчилд оногдуулсан торгуулийн орлогын 20-оос доошгүй хувийг дүрс бичлэгийн техник, мэдээллийн системийг сайжруулах, мөн хэмжээний хөрөнгийг урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараа жилийн төсөвт тусгаж

санхүүжүүлэх зохицуулалттай. Үүнийг үндэслэн аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлахдаа холбогдох зардлыг урьдчилан тооцоолж тусгах шаардлагатай байна.

1.2.4.3 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд хүүгийн орлогыг төлөвлөхгүй байгаа нь ямар зардлыг санхүүжүүлэх нь тодорхойгүй байдал үүсгэж, санхүүгийн сахилга бат, үр ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд хүүгийн орлогын төлөвлөлтийг сайжруулж, зориулалт, үр ашгийг тодорхой болгох шаардлагатай байна.

A.2.5 Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна.

1.2.5.1 Орон нутгийн төсвийн хүү, торгуулийн орлогын гүйцэтгэл 2023 онд төлөвлөгөөнөөс 160 хувиар буюу 774.6 сая төгрөгөөр давсан ч, 2024 онд орлогын гүйцэтгэл 1,367.7 сая төгрөгөөр тасарсан нь тухайн орлогын төлөвлөлттэй шууд холбоотой байна. Тодруулбал, 2024 оны хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг орлогын бүтэц, бүрдлийн эх үүсвэр, өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэлгүйгээр, нарийвчилсан тооцоо судалгаагүй, хэт өөдрөгөөр боловсруулсан нь тасрах үндсэн шалтгаан болсон байна.

1.2.5.2 Энэхүү төлөвлөлтийн алдаа нь орлогын эх үүсвэрт үндэслэлгүй, бүрэн бус мэдээлэлтэй хандсанаас гадна, төсвийн бодит байдалд нийцээгүй зорилт тодорхойлсон, орлогын гүйцэтгэлд суурилсан төсвийн сахилга бат, санхүүгийн зохистой төлөвлөлт алдагдахад нөлөөлсөн сөрөг үр дагавартай юм.

1.2.5.3 Санхүүгийн тайлангийн аудитаар уг зөрчлийг илрүүлж, дараа оны орлогын төлөвлөгөөг үнэн зөв, бодит тоон мэдээлэлд тулгуурлан боловсруулах, судалгаа тооцоог сайжруулах, төлөвлөлтийн үндэслэл, аргачлалыг боловсронгуй болгох талаар мэргэжлийн зөвлөмж хүргүүлсэн болно.

A.3 Эрх зүйн зохицуулалтыг нэг мөр түвшинд мөрдүүлэх, орон нутгийн төсвийн орлогыг бүрэн, оновчтой бүрдүүлэх нөхцөлийг хангах шаардлагатай байна.

A.3.1 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон заалтын дагуу холбогдох журмыг шинэчлэн батлаагүй нь хуулийн хэрэгжилтийг хангах зохицуулалт бүрдээгүй, санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэлд тодорхойгүй байдал үүсгэх нөхцөл болж байна.

1.3.1.1 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5-т “Нийгмийн даатгалын сангийн орлого нь шимтгэлийн өр авлага, цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогыг нуусан, бууруулсан зэрэг нөхцөлөөс үүссэн алданги, торгуулиас бүрдэнэ” гэж заасан. Мөн Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.5.4-т “Нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний болон авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухайн орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд төвлөрүүлнэ” гэж тусгасан байдаг.

1.3.1.2 Гэвч дээрх заалтууд нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7, 23.9-т “төрийн байгууллагад оногдуулсан торгууль, алдангийн орлогыг тухайн шатны

төсөвт төвлөрүүлнэ” гэж заасантай уялдахгүй, зохицуулалтын давхардал, зөрчил үүсгэж байна.

1.3.1.3 Салбарын хуулиар торгуулийн орлогын зориулалт, төвлөрүүлэх байршлыг нарийвчлан тогтоосон боловч төсвийн эрх зүйн суурь зохицуулалт болох Төсвийн тухай хуультай нийцүүлээгүйгээс ийм нөхцөл байдал үүссэн. Энэ нь торгуулийн орлогын төвлөрөлд тодорхойгүй байдал бий болгож, хуваарилалт, тайлагналд зөрүү үүсгэх, зарим байгууллага орлогыг үндэслэлгүйгээр зарцуулах, төсвийн сахилга, ил тод байдал алдагдах эрсдэл дагуулж байна.

1.3.1.4 Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан 88/152 дугаар тушаалаар мөрдөгдөж буй “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журам”-д орлогын 40 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан санхүүжүүлэхээр тогтоосон байдаг.

1.3.1.5 Харин 2019 онд шинэчлэн найруулсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 46.1-д “40-өөс доошгүй хувь” гэж заасан нь тухайн журмын “40 хувьтай тэнцэх” гэсэн заалттай зөрчилдөж байгаа нь зохицуулалтын зөрүү бий болгож байна.

1.3.1.6 Шинэчлэгдсэн хуульд заасан санхүүжилтийн хувь хэмжээ, зориулалт, ашиглалтын уян хатан нөхцөл зэргийг тусгасан, хэрэгжилтийн механизмыг нарийвчилсан журмыг шинэчлэн батлах шаардлага үүссэн бөгөөд энэ нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүгийн хувьд тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

А.3.2 Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ хуульчлагдсан байна.

1.3.2.1 Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын харилцахын үлдэгдэлд Монгол улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үндэслэн банктай байгуулсан гэрээний дагуу 0-10 сая төгрөг хүртэл 0%, 10-50 сая төгрөг хүртэл 1.2%, 50.0 сая төгрөгөөс дээш үлдэгдэлд 2 хувийн хүү тооцож хүүгийн орлогыг олгодог байна.

А.3.3 Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсвийн орлогод хамаарах 291.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

1.3.3.1 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7, 23.9, түүнчлэн 23.7.2, 23.9.2 дахь заалтуудад орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, борлуулсны орлого, хүү, торгуулийн орлогыг орон нутгийн төсвийн татварын бус орлогын бүрэлдэхүүнд хамааруулан тусгасан байдаг. Энэхүү зохицуулалтын дагуу босоо удирдлагатай эрх бүхий албан тушаалтнаас ногдуулсан торгуулийн орлого нь тухайн орон нутгийн төсвийн орлого болж төвлөрөхөөр байна. Гэтэл 2023–2024 оны хугацаанд нийт 291.3 сая төгрөгийн торгуулийн орлого нь улсын төсвийн дансанд төвлөрсөн байна.

1.3.3.2 Уг орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь тухайн орон нутгийн төсвийн бодит орлогыг бууруулж, улмаар санхүүгийн чадавхыг хязгаарлах, иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмж буурах, чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг бий болгож байна.

Иймд эрх зүйн зохицуулалтыг нэг мөр түвшинд мөрдүүлэх, орон нутгийн төсвийн орлогыг бүрэн, оновчтой бүрдүүлэх нөхцөлийг хангах шаардлагатай байна.

А.3.4 Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж буй эсэхэд Прокурорын байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн байна.

1.3.4.1 Прокурорын байгууллагаас хийсэн хяналтын үр дүнд 143 иргэн, аж ахуйн нэгжид ногдуулсан торгуулийн шийтгэлийн хуудсыг хуулийн заалтыг буруу хэрэглэсэн, үйлдсэн зөрчилтэйгөө нийцээгүй үндэслэлээр хүчингүй болгож, 646 шийтгэлийн хуудсанд өөрчлөлт оруулсан байна. Мөн дээрх хууль зөрчсөн шийдвэрүүдийг гаргасан эрх бүхий албан тушаалтанд дахин давтан ийм үйлдэл гаргуулахгүй байх талаар прокурорын байгууллагаас албан шаардлага хүргүүлжээ. Хүчингүй болсон шийтгэлийн дагуу торгуулиа төлсөн иргэн, аж ахуйн нэгжийн төлсөн мөнгийг буцаан олгуулсан байна. Харин бусад хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, торгууль ногдуулсан эрх бүхий албан тушаалтнуудын харьяалагдах дээд байгууллагын зүгээс тухайн шийдвэрүүд хуульд нийцсэн эсэх талаар эцсийн шийдвэр гаргаагүй байна.

А.3.5 Цахимаар оногдуулсан торгууль хууль хэрэглээ, бүх нийтэд адил тэгш үйлчилж чадаж байгаа эсэх нь хязгаарлагдмал байна.

1.3.5.1 Эрх бүхий албан тушаалтны хэрэглэсэн хуулийн заалт нь гарсан зөрчилтэй нь нийцсэн эсэхэд Прокурорын байгууллагаас хяналт хэрэгжүүлж хуульд нийцээгүй бол хүчингүй болгох, шийтгэврийн хуудсанд өөрчлөлт оруулах арга хэмжээ авч иргэдэд хуулийг тэгш хүртээмжтэй үйлчлэхэд анхаарч байна.

1.3.5.2 Харин Цагдаагийн байгууллагын цахимаар оногдуулж буй торгуулийн арга хэмжээнд иргэн өөрөө гомдол гаргаж шийдвэрлүүлээгүй тохиолдолд хуулийг тэгш хүртээмжтэй хэрэглэсэнд хяналт тавих боломж хязгаарлагдмал байна.

А.3.6 Торгууль төлөлтийг хангах эрх зүйн хөшүүргийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.3.6.1 Торгуулийн орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлэх чиглэлээр 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш оногдуулсан торгуулийг 15 хоногийн дотор төлсөн тохиолдолд 50 хувийн хөнгөлөлт эдлэх зохицуулалт үйлчилж байгаа бөгөөд мөн тээврийн хэрэгсэл худалдсан үед хамаарах торгуулийг төлүүлэх арга хэмжээ авдаг бөгөөд бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж торгуулийг хугацаанд төлөөгүй нөхцөлд хариуцлага тооцох, төлбөр барагдуулах үр нөлөөтэй санхүүгийн болон санхүүгийн бус арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

1.3.6.2 Үүний улмаас торгуулийн орлого бүрэн төвлөрөхгүй, төсөвт орох ёстой хөрөнгийн тасалдал үүсэх, хууль хэрэгжилтийн тэгш байдал алдагдах, иргэд төлбөрийн сахилга батгүй байх зэрэг сөрөг үр дагавар бий болж байна.

1.3.6.3 Торгуулийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэхэд төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй хөшүүрэг, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Олон улсын сайн туршлагаас харахад торгууль ногдуулах, төлүүлж барагдуулах үйл явцыг орлогоос хамааруулсан торгууль, төрийн үйлчилгээтэй уялдуулсан хязгаарлалт, хөнгөлөлт-урамшууллын тогтолцоо, нэгдсэн цахим системээр дамжуулан сайжруулж байна. Иймд Монгол Улсад торгуулийн хэрэгжилтийг

нэмэгдүүлэх, шударга тэгш байдлыг хангах, төлбөрийн сахилга батыг сайжруулах зорилгоор эрх зүйн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

А.3.7 Торгуулийн орлого нь хууль ёсны арга хэмжээ тул иргэний өмчийг шууд хөндөхгүй боловч, хяналтын механизм сайжруулах шаардлагатай байна.

1.3.7.1 Иргэний өмчийн халдашгүй байдал гэдэг нь хувь хүний өмч хөрөнгийг хууль ёсны эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусад этгээд дур мэдэн авах, булаах, устгах, гэмтээх, ашиглах зэрэг аливаа үйлдлийг хориглож, төрөөс хамгаалах эрх зүйн үндэс юм. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомжид энэхүү эрхийг тодорхой хамгаалж, хуулийн хүрээнд зөвхөн өмчлөгчийн зөвшөөрөл болон хуульд заасан онцгой нөхцөлд л өмчид нөлөөлөх боломжтой гэдгийг заасан байдаг.

1.3.7.2 Торгуулийн орлого нь хууль зөрчсөн этгээдэд ногдуулсан мөнгөн торгууль бөгөөд үүнийг иргэний өмчийн халдашгүй байдалд шууд халдсан гэж үзэх боломжгүй юм. Учир нь торгууль нь хуульд нийцсэн, төрийн зохицуулалт, шийдвэрийн нэг хэлбэр бөгөөд өмч хөрөнгөөр бусад эрх ашигт халдах бус, хууль зөрчсөн үйлдлийг зохицуулах арга хэмжээний нэг хэлбэр юм.

1.3.7.3 Гэхдээ торгуулийн орлогыг төвлөрүүлэх, зарцуулах журам, хяналт, аудитын тогтолцоо бүрэн төгс биш, заримдаа эрх зүйн зохицуулалтууд хоорондоо зөрчилдөж, хяналт сул байгаагаас шалтгаалан орлого бүрэн төвлөрөхгүй, зарцуулалтын ил тод байдал хангагдахгүй байна. Тухайлбал, торгуулийн зарим орлого улсын төсөвт төвлөрч, орон нутгийн төсвийн орлого буурах, зарцуулалтын үр ашгийг бууруулах, холбогдох байгууллагын хяналт сулрах, иргэдийн итгэл алдагдах эрсдэл байна.

БҮЛЭГ Б. СҮХБААТАР АЙМАГТ 2023-2024 ОНД НИЙТ 46,622 ЗӨРЧИЛД 2,437.3 САЯ ТӨГРӨГИЙН ТОРГУУЛЬ НОГДУУЛЖ, ҮҮНЭЭС 2,070.5 САЯ ТӨГРӨГ БУЮУ 84.5 ХУВЬ НЬ ТӨВЛӨРСӨН БАЙНА.

Б.1 Торгуулийн орлого төсөвт бүрэн төвлөрөөгүй, төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна.

Б.1.1 Тогтоосон торгуулийн орлого төсөвт бүрэн төвлөрөөгүй байна.

2.1.1.1 Сүхбаатар аймагт 2023-2024 онд нийт 46,622 зөрчилд 2,437.3 сая төгрөгийн торгууль ногдуулж, үүнээс 2,070.5 сая төгрөг буюу 84.5 хувь нь төвлөрсөн бол 366.9 сая төгрөг буюу 15.5 хувь нь төвлөрөөгүй байна. Төвлөрөөгүй үлдэгдлийн ихэнх хувийг Цагдаагийн газрын ногдуулсан торгуулийн орлого эзэлж байна. Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, БОГ зэрэг байгууллагууд дутуу төвлөрсөн орлогыг бүрэн төвлөрүүлэх үүднээс хууль, хяналтын байгууллагад хандсан байна.

Хүснэгт №5 2023-2024 онд ногдуулсан торгуулийн орлого /сая төгрөг/

Д/Д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Зөрчлийн тоо	Ногдуулсан	Төвлөрсөн
1	Сүхбаатар аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	7	2.9	2.9
2	Сүхбаатар аймгийн Мал эмнэлэгийн газар	2	1.5	1.5
3	Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар	71	193.4	193.4

4	Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа	2	1.0	1.0
5	Сүхбаатар аймгийн байгаль орчны газар	60	104.3	91.0
6	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар	21	14.5	13.5
7	Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар	14	11.4	11.4
8	Сүхбаатар аймгийн Татварын газар	93	634.4	634.4
9	Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газар	18	11.0	11.0
10	Сүхбаатар аймгийн улсын бүртгэлийн хэлтэс	569	16.6	16.7
11	Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	20	51.7	51.7
12	Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	40	60.5	41.5
13	Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	4	3.3	3.3
14	Сүхбаатар аймгийн Автотээврийн төв	34	6.6	6.6
15	Сүхбаатар аймгийн цагдаагийн газар	45,524	1,169.9	883.3
16	Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар	36	143.6	96.6
17	Сүхбаатар аймгийн онцгой байдлын газар	26	2.6	2.6
18	Хилийн цэргийн 0146 дугаар анги	32	3.2	3.2
19	Хилийн цэргийн 0184 дүгээр анги	49	4.9	4.9
	Нийт	46,622	2,437.4	2,070.5

2.1.1.2 Цагдаагийн байгууллагын ногдуулж буй торгуулийн орлого 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөгдөж эхэлсэн журамд зааснаар, бичигдсэн торгуулийн нэхэмжлэхийг тухайн торгуулсан өдрөөс хойш 15 хоногийн дотор төлсөн тохиолдолд 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх зохицуулалт бий. Мөн авто тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлсэн бол тухайн төлөгдөөгүй торгуулийг шилжүүлэн авах арга хэмжээ авдаг боловч бусад төрлийн торгуулийн орлогыг хугацаанд төвлөрүүлэх, төлүүлж ажиллах талаар тодорхой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

2.1.1.3 Үүний улмаас төвлөрөх ёстой орлого бүрэн төвлөрөхгүй, төсвийн санхүүжилт тасалдаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээ болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тиймээс торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, төлөлт хойшлохыг бууруулах, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, торгуулийн төлөлтийн арга хэмжээг илүү оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Б.1.2 Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан ногдуулсан байна.

2.1.2.1 Торгуулийг улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтан, эрх бүхий байгууллага хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авсан байна.

Б.1.3 Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгасан байна.

2.1.3.1 Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,059.6 сая төгрөг, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,755.3 сая төгрөгийн хүү, торгуулийн орлого төвлөрч тайлагнасныг санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан.

Б.1.4 Хүү, торгуулийн төлөөгүй үлдэгдлийг төвлөрүүлбэл нийт орлогод эзлэх хувь нэмэгдэхээр байна.

2.1.4.1 Сүхбаатар аймгийн татварын нийт орлого 2024 оны гүйцэтгэлээр 13,225.3 сая төгрөг байгаа бөгөөд хүү, торгуулийн орлого нийт татварын орлогын 6.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт №6 Нийт татварын орлогод эзлэх хувь хэмжээ /сая төгрөг/

№	Сумын нэр	2023 он			2024 он		
		Нийт орлого	Торгуулийн орлогын Гүйцэтгэл	Эзлэх хувь	Нийт орлого	Торгуулийн орлогын Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	Аймаг	20,227.0	1,181.8	5.8	13,225.3	912.1	6.9
2	Асгат	444.7	13.6	3.1	469.5	14.1	3.0
3	Баяндэлгэр	771.2	30.8	4.0	1,272.0	18.5	1.5
4	Дарьганга	534.0	25.6	4.8	708.6	25.2	3.6
5	Мөнххаан	715.8	82.3	11.5	941.3	84.9	9.0
6	Наран	268.4	1.1	0.4	480.3	2.1	0.4
7	Онгон	840.4	16.6	2.0	1,275.1	6.5	0.5
8	Түвшинширээ	439.7	6.1	1.4	669.0	4.8	0.7
9	Түмэнцогт	728.0	91.2	12.5	695.4	105.4	15.2
10	Уулбаян	487.6	16.7	3.4	647.0	8.1	1.3
11	Халзан	406.9	3.9	1.0	367.7	4.0	1.1
12	Эрдэнэцагаан	1,773.2	53.9	3.0	2,018.5	61.3	3.0
13	Баруун-Урт	9,719.9	519.2	5.3	13,262.5	504.6	3.8
14	Сүхбаатар	1,143.7	16.8	1.5	1,300.3	3.9	0.3
Нийт дүн		38,500.5	2,059.6	5.3	37,332.5	1,755.5	4.7

2.1.4.2 Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024 онд торгуулийн орлого 1,755.5 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 304.3 сая төгрөгөөр буюу 14.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүний зэрэгцээ нийт татварын орлогод эзлэх хувийн жин 2023 онд 5.3 хувь байсан бол 2024 онд 4.7 хувь болж 0.6 нэгж хувиар буурсан нь торгуулийн орлогын төвлөрөл, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө зарим сумдад буурсан болохыг харуулж байна. Тоймлон авч үзвэл:

- Эзлэх хувь буурсан сум 10 байна. Үүнд Сүхбаатар, Баруун-Урт, Мөнххаан, Дарьганга, Баяндэлгэр зэрэг сумд орсон бөгөөд үүнээс Сүхбаатар сум 1.5%-аас 0.3% болж хамгийн огцом буурсан.
- Эзлэх хувь өссөн сум 4 байна. Үүнд Аймаг (төвлөрсөн орлого), Асгат, Түмэнцогт, Халзан сум орж байна.
- Түмэнцогт сум 2023 онд 12.5%, 2024 онд 15.2% эзлэх хувиар хамгийн өндөр төвлөрөл бүхий сум хэвээр байна.
- Мөнххаан сум торгуулийн орлогын дүнгээр өндөр ч эзлэх хувь нь 11.5%-аас 9.0% болж буурсан.
- Баруун-Урт сум хамгийн өндөр орлоготой (504.6 сая төгрөг) боловч нийт орлогод эзлэх хувийн жин 5.3%-аас 3.8% болж буурсан.
- Наран, Онгон, Түвшинширээ, Сүхбаатар сумдад торгуулийн орлогын төвлөрөл туйлын бага буюу 1 хувиас доогуур үзүүлэлттэй байна.

2.1.4.3 Орон нутгийн зарим нэгжид торгууль ногдуулах, биелүүлэх, бүртгэх, тайлагнах үйл ажиллагаа жигд бус, үр нөлөө сул байгааг дээрх хандлага илтгэж байна.

2.1.4.4 Торгуулийн орлогыг үр ашигтай төвлөрүүлэхэд хяналт-шинжилгээ, хэрэгжилт, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Б.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөрөнгийг хуульд заасны дагуу өмнөх жилийн орлогын гүйцэтгэлээр хуваарилаагүй байна.

Б.2.1 Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байна.

2.2.1.1 Аймаг, сумдын ИТХ-аар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2023 онд 161.8 сая, 2024 онд 421.1 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

2.2.1.2 Асгат, Уулбаян, Сүхбаатар, Халзан, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсвийг тухайн онд төвлөрүүлсэн торгуулийн орлогын 40 хувиас бага хуваарилж баталсан нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтад нийцэхгүй байна.

Б.2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт нь хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

2.2.1.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу өмнөх жилийн торгуулийн орлогын гүйцэтгэлд үндэслэн тооцож, хуваарилаагүй байна. Тухайлбал:

- Аймаг, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт сум 2023, 2024 онд энэ чиглэлээр зарцуулах төсвийг ижил хэмжээтэй баталсан нь өмнөх оны орлогын гүйцэтгэлийг харгалзан үзээгүйг илтгэж байна.
- Дарьганга, Наран, Түвшинширээ сум нь торгуулийн орлогын 40 буюу түүнээс дээш хувийг дээрх арга хэмжээнд хуваарилсан бол бусад сумд уг хувь хэмжээнээс бага дүнгээр хуваарилалт хийсэн нь хуулийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Б.2.4 Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг Цагдаа, Санхүү хяналт дотоод аудитын албанаас бусад байгууллага харгалзан үздэггүй байна.

2.4.2.1 Цагдаагийн газар болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь торгууль ногдуулсан эрх бүхий албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн албан хаагчийн гаргасан шийтгэлийн биелэлт, төвлөрүүлсэн орлогын хэмжээг гол шалгуур болгон ашиглаж, гүйцэтгэлийн тайланд тусган үнэлж байна.

2.4.2.2 Харин бусад торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан шийдвэрийн хэрэгжилт, төвлөрүүлсэн орлогын үзүүлэлтийг албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд харгалзан үздэггүй, гүйцэтгэлийн тайланд тусгадаггүй байна.

2.4.2.3 Бусад эрх бүхий албан тушаалтнуудын торгуулийн шийдвэрийн хэрэгжилт, төвлөрлийг тогтмол үнэлэх, гүйцэтгэлийн тайланд бүрэн тусгах системийг нэвтрүүлснээр үнэлгээний ил тод байдал, хариуцлага сайжирч, орлого бүрдүүлэлт нэмэгдэх боломж бүрдэхээр байна.

БҮЛЭГ В: ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ ЗАРИМ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ БАЙНА.

В.1 Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулжээ.

В.1.1 Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан ч зарим хэрэгжүүлсэн ТАХ чанарын шаардлага хангахгүй байна.

3.1.1.1 Авто замын сан нь тээврийн хэрэгсэлд ногдуулж байгаа торгуулийн орлогын тодорхой хэсгээр бүрддэг бөгөөд замын сангийн хөрөнгөөр 2024 онд өмнөх оноос шилжиж ирсэн 2,314.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг 708.9 сая төгрөгөөр, шинээр 756.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

Хүснэгт №7 Замын сангаар хийгдсэн ТАХ /сая төгрөг/

д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	хэрэгжих хугацаа	төсөвт өртөг	2024 онд санхүүжих	гүйцэтгэл	гүйцэтгэгч
1	Шилжих хөрөнгө оруулалт					
1.1	Зэвсэгт хүчний 338 дугаар анги хүртэлх хатуу хучилттай автозам / Баруун-Урт сум, /	2022-2024	751.8	50.9		Монгол зам групп ХХК
1.2	Баруун-Урт сумын төвийн хатуу хучилттай автозам, замын байгууламжийн хэсэгчилсэн засвар, нөхөөс /2-р тойрог/	2022-2024	180.0	72.8		Ханан салхит ХХК
1.3	Эко хорооллын автозамын ажил / Баруун-Урт сум, 7-р баг/	2023-2024	500.0	408.2	302.3	Монгол зам групп ХХК
1.4	Аймгийн авто замын засвар нөхөөс	2023-2024	350.0	129.6		Монгол зам групп ХХК
1.5	Баруун-Урт сумын 1-р баг 60 айл, Грийн таун, музей чиглэлийн автозам /630м+400м/	2022-2024	520.0	34.1		Талын зам ТӨХК
1.6	Том оврын автомашины хөдөлгөөн хязгаарлах тэмдэг тэмдэглэгээ	2023-2024	13.0	13.0		
	ДҮН		2,314.8	708.9	302.3	
	Шинэ хөрөнгө оруулалт					
2.1	Авто замын хэсэгчилсэн засвар, арчлалт, нөхөөс ус зайлуулах хоолой барих (Баруун-Урт сум)	2024	192.0	192.0	171.0	Талын зам ХХК
2.2	Боловсрол хорооллын хойд хэсгийн авто зам	2024	564.0	564.0	140.5	Поларис реүд инженеринг ХХК
	ДҮН		756.0	756.0	311.5	

	НИЙТ ДҮН		3,070.8	1,464.9	613.8	
--	----------	--	---------	---------	-------	--

3.1.1.2 Зэвсэгт хүчний 338 дугаар анги хүртэлх хатуу хучилттай автозам /Баруун-Урт сум/, Баруун-Урт сумын төвийн хатуу хучилттай автозам, замын байгууламжийн хэсэгчилсэн засвар, нөхөөс /2-р тойрог/, Аймгийн авто замын засвар нөхөөс, Баруун-Урт сумын 1-р баг 60 айл, Грийн таун, музей чиглэлийн автозам /630м+400м/ төсөл, арга хэмжээнүүд ажил дутуу, чанаргүй хийгдсэн нь улсын комиссын актаар тогтоогдсон тул гүйцэтгэгчээр дахин хийлгэх дүгнэлт гарсан тул санхүүжилт олгоогүй, эко хорооллын автозамын ажил /Баруун-Урт сум, 7-р баг/ ажлын гэрээ сунгагдаж он дамжин хийгдэхээр болсон байна.

3.1.1.3 Авто замын хэсэгчилсэн засвар, арчлалт, нөхөөс хийх /Баруун-Урт сум/ ажлыг 180.0 сая төгрөгөөр Талын зам ТӨХК гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан байна. Гэтэл Тэспетролиум чиглэлийн автозамын хэсэгт ус зайлуулах шугам байхгүйгээс хийсэн ажил чанарын баталгааны хугацаанаас өмнө эвдэрсэн, Номин супермаркетын урд талаас Залуус хотхон хүртэлх замын суурь солих шаардлага үүссэн байна. Дээрх замуудад ус зайлуулах хоолой хийх, замын суурийг бүхэлд нь шинэчлэх, нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай байна.



3.1.1.4 Авто замын засвар, нөхөөсний чанар хангалтгүй, техникийн дутуу судалгаа, ус зайлуулах шугам, суурийн баталгаа болон хяналт шалгалтын үйл явцын алдаа нь улсын комисс хүлээн аваагүй гүйцэтгэлд хүргэж, дахин чанартай хийх шаардлага үүсгэсэн байна.

В.1.2 Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлээгүй байна.

3.1.2.1 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтын дагуу 2023-2024 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан чиглэлээр сургалтын материал, зурагт хуудас хэвлүүлэх, Цагдаагийн газарт согтуурал шалгагч багаж худалдан авах, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах сургалт явуулах, метал илрүүлэгч багаж авах, аймгийн Прокурорын газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зориулалттай киоск машин байрлуулах, олон нийтийн цагдаагийн цалин, НДШ зэрэг зардлыг эдийн засгийн ангиллаар бүртгэн зарцуулсан байна.

3.1.2.2 Замын сангийн хөрөнгийн санхүүжилтийг эдийн засгийн ангилал хооронд зохицуулалт хийгээгүй, зориулалт бусаар зарцуулаагүй байна.

В.1.3 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь олон нийтэд хүртээмжтэй байна.

3.1.3.1 Тайлант онуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 9 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 5,984 иргэн сургалтад хамрагдаж мөн тоогоор гарын авлага, санамж, зөвлөмж тарааж ажилласан байна.

3.1.3.2 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд авто замын арчлалт хамгаалалт, явган хүний зам шинээр тавих, замын тэмдэг тэмдэглэгээ сайжруулах, нийтийн эзэмшлийн зам талбай нэмэгдүүлэх ажлыг хийснээр олон нийтэд хүртээмжтэй ажил болсон байна.

В.1.4 Нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлсэн байна.

3.1.4.1 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хүрээнд аймгийн Цагдаагийн газарт согтуурал шалгагч багаж худалдан авахад 3.6 сая, “Нэг зам нэг соёл” арга хэмжээ зохион байгуулахад 2.3 сая, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим дэлгэц авахад 3.0 сая, гарын авлага бэлтгэхэд 2.5 сая, Баруун-Уртаас Мөнххаан чиглэлийн замд анхааруулах самбар байрлуулахад 0.9 сая, мөн автозамын тэмдэг, тэмдэглэгээ шинэчлэх, замын эвдрэл засварлахад 108.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.1.4.2 Гэвч аймгийн нутаг дэвсгэрээр зорчиж буй авто машины тоо жил бүр өсөж байгаатай холбоотой зам тээврийн осол, зөрчлийн тоо нэмэгдсээр байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, зам тээврийн зөрчлийн тоо 2023 онд 21,189 байсан бол 2024 онд 24,335 болж, өмнөх оноос 3,146-гаар нэмэгдсэн байна. Энэ нь осол, зөрчлийн түвшнийг бууруулах талаар илүү үр дүнтэй, шинэлэг арга хэмжээ авах шаардлагатайг илтгэж байна. 3.1.4.3 Мөн 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш бичигдсэн торгуулийн нэхэмжлэх бүрт 15 хоногийн дотор төлбөл 50 хувийн хөнгөлөлт тооцох журам хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан зөрчлийн тоо нэмэгдсэн ч торгуулийн орлого 62.5 сая төгрөгөөр буурсан нь санхүүгийн урсгалд нөлөөлж байна. Иймд торгуулийн орлогын төвлөрүүлэлт, хяналт, торгуулийн бодлогоор иргэдийн хүлээх үүрэг хариуцлагыг сайжруулах шаардлага байна.

3.1.4.4 Зам тээврийн ослын тоо, зөрчлийн өсөлтийг бууруулахын тулд иргэдийн замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх, сургалт сурталчилгааг тогтмол, өргөн хүрээнд зохион байгуулах шаардлагатай бөгөөд торгуулийн журамд хөнгөлөлтийн бодлогыг дахин эргэн харж, хууль, журам сахиулах механизм, хяналтыг сайжруулах, мөн торгуулийн орлогыг төвлөрүүлэх, зарцуулах үйл ажиллагааг ил тод, үр дүнтэй болгох нь чухал юм. Ийм арга хэмжээ нь иргэдийн хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн осол, зөрчлийг бууруулах, төсвийн орлогыг тогтвортой болгоход дэмжлэг болох юм.

В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлж байна.

В.2.1 Аймгийн ИТХ 5.0 сая төгрөгөөс дээш 38.7 сая төгрөгийн 6 зардлын гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлсэн байна.

3.2.1.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасан байна.

3.2.1.2 Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 5.0 сая төгрөгөөс дээш 38.7 сая төгрөгийн 6 зардлын гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлсэн байна.

В.2.2 Шилэн дансны цахим сайтад хүү, торгуулийн орлогын зарцуулалтын тайлан, мэдээллийг мэдээлж байна.

3.2.2.1 Аймаг, сумдын ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарцуулалтыг шилэн дансны цахим сайтаар мэдээлж, ил тод байдал болон олон нийт хяналт тавих боломжоор ханган ажиллаж байна.

3.2.2.2 Сүхбаатар аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 2023, 2024 онд тус тус 46 арга хэмжээ бүхий гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

В.2.3 Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой ил тод байдалд үнэлгээ хийгээгүй байна.

3.2.3.1 Хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотойгоор иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас албан ёсны үнэлгээ, санал, дүгнэлт ирүүлээгүй байна.

3.2.3.2 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, осол зөрчлийг бууруулах, мөн торгуулийн орлогын төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс иргэдэд зориулсан тогтмол сургалт, сурталчилгааг зохион байгуулах, торгуулийг цахим системээр хялбар, шуурхай төлөх боломжийг бий болгох, хөнгөлөлтийн нөхцөлийг дэлгэрүүлэх шаардлагатай байна. Мөн согтуурал шалгагч багаж, замын тэмдэг, самбар зэрэг техникийн хангамжийг сайжруулж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм. Торгуулийн орлогоор санхүүжүүлэх замын засвар, сурталчилгааны ажлуудыг ил тод, үр дүнтэй гүйцэтгэх нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг нэмэгдүүлж, нийтийн эрх ашгийг хамгаалахад чухал хувь нэмэр болох юм.

БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТ ТАВЬЖ БАЙГАА Ч ИРГЭД, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ ЗЭРЭГ ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ОРОЛЦУУЛАХ, ИЛ ТОД, ХҮРТЭЭМЖТЭЙ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА ҮҮСЭЭД БАЙНА.

Г.1 Улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Г.1.1 Хүү, торгуулийн орлогын мэдээллийн санг бүрдүүлэхгүй байгаа нь төсвийн орлогын бүрэн, бодит мэдээлэлд тулгуурлан төлөвлөх, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.


4.1.1.1 Одоогийн байдлаар улсын хэмжээнд зөвхөн Статистикийн мэдээллийн нэгдсэн санд (www.1212.mn) тодорхой хүрээнд мэдээлэл нийтлэгдэж байгаа бол Нийгмийн даатгалын SIGOS, Татварын TAIS, Цагдаагийн байгууллагын систем зэрэг салбар бүрт өөрсдийн дотоод системд хүү, торгуулийн орлогыг бүртгэн тайлагнаж байгаа нь мэдээллийн нэгдмэл, уялдаа холбоогүй байдал үүсгэж байна.

4.1.1.2 Иймд хүү, торгуулийн орлогын нэгдсэн мэдээллийн санг бий болгож, холбогдох байгууллагуудын мэдээллийг нэгтгэн хянах тогтолцоог бүрдүүлснээр төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд суурь дүнгийн үнэн зөв байдлыг хангах, ил тод байдал, хараат бус хяналтыг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Г.1.2 Торгуулийн төлбөрийг системээр дамжуулан барагдуулах нь цаг хугацаа хэмнэх давуу талтай байна.

4.1.2.1 Иргэд [Smartcar.mn](#), E-Монголиа, [Ebarimt.mn](#), Токи, Гэрэгэ, MostMoney, Gerege болон арилжааны банкаар дамжуулан торгуулийн төлбөрийг төлж барагдуулах боломжтой байна.

4.1.2.2 Цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгуулийн зөрчлийн тоон үзүүлэлтээр гаргасан хүснэгтээс харахад 31 хувь нь E-Монголиа, 28 хувь нь Төрийн банк, 21 хувь нь Гэрэгэ, 13 хувь нь Smartcar, 7 хувь нь бусад төлбөрийн хэрэгслийг ашигласан байна.



4.1.2.3 Торгуулийн төлбөрийн цахим системүүд нь өдөр шөнийн аль ч үед төлбөр төлөх боломж, цаг хугацаа хэмнэх, ил тод байдал, баримтжуулалт, найдвартай байдал, автоматжуулсан тайлан мэдээлэл зэрэг давуу талуудыг бий болгож байна.

Г.1.3 Хяналтын системийн хэрэгжилт хангалтгүй байна.

4.1.3.1 Татвар, Цагдаа, Гаалийн байгууллагаас бусад байгууллагын хувьд торгуулийн орлогын бүртгэл, хяналтын нэгдсэн мэдээллийн систем бүрдээгүй нь орлогын бодит гүйцэтгэл, хяналтын ил тод байдал, тайлагналд сөргөөр нөлөөлж байна. Ийм нөхцөлд орлогын бүрдүүлэлтийн хариуцлагыг зөвхөн тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн ажиллаж байгаа нь дотоод хяналтын чадавх, хариуцлагын тогтолцоонд эрсдэл үүсгэж байна. Харин мэдээллийн нэгдсэн системтэй байгууллагуудын хувьд төвлөрүүлсэн орлогын хэмжээнд хяналт тавих, тайлан, мэдээг цаг хугацаанд нь гаргах, төлөгдөөгүй торгуулийн талаар дараагийн шатны арга хэмжээ авах зэрэг бодит үр нөлөөтэй зохицуулалтууд хэрэгжиж байгаа нь нэгдсэн системийн ач холбогдлыг илтгэж байна. Иймд бүх байгууллагын торгуулийн орлогыг хамарсан мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх шаардлагатай.

4.1.3.2 Торгуулийн орлого бүрдүүлэх, хянах, тайлагнах бүхий л үе шатанд мэдээллийн технологид суурилсан **нэгдсэн төвлөрсөн систем** ажиллуулдаг улс орон цөөнгүй байна. Энэ нь холбогдох байгууллагууд (шүүх, цагдаа, татвар, прокурор, гааль, даатгал гэх мэт) хооронд реал-тайм дата солилцох, автомат хяналт хийх, торгуулийн биелэлтэд цахим сануулга өгөх, төлбөрийг онлайнаар төлөх, хариуцлага тооцох цогц боломжийг бүрдүүлдэг.

4.1.3.3 Иймд төрийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэсэн **“Торгуулийн орлогын нэгдсэн цахим систем”** бий болгох нь зүйтэй. Уг системийг үе шаттайгаар нэвтрүүлснээр орлогын бүрдүүлэлтийн бодит байдалд хяналт тавих, зөрчил гаргасан иргэн, байгууллагад оновчтой арга хэмжээ авах, төсвийн төлөвлөлт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, мөн иргэдийн оролцоо, итгэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага байна.

Г.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны цахим системд мэдээлж байна.

Г.2.1 Торгуулийн орлого бүрэн төвлөрөхгүй байгаа нь хяналт, хэрэгжилтийн тогтолцоо сул байгааг илтгэж байна.

4.2.1.1 Цагдаагийн байгууллагаас 2023, 2024 онд 1,169.9 сая төгрөгийн торгууль ногдуулснаас гүйцэтгэлээр 883.3 сая төгрөгийн орлогыг аймаг, орон нутгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №8 Цагдаагийн байгууллагын торгуулийн орлогын төвлөрүүлэлт /сая төгрөг/

Он	Ногдуулсан	Төвлөрүүлсэн				Зөрүү
		2023	2024	2025	Нийт	
2023	596.8	199.1	211.0	62.8	472.9	123.9
2024	573.1	-	279.8	130.6	410.4	162.7
Нийт	1,169.9	199.1	490.8	193.4	883.3	286.6

4.2.1.2 Тайлант хугацаанд торгуулийн орлогын 24.5 хувь буюу 286.6 сая төгрөг бүрэн төвлөрөөгүй, торгууль ногдуулсан тухайн жилд төвлөрсөн орлого 2023 онд 33 хувь, 2024 онд 49 хувьд хүрсэн нь торгуулийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа хангалтгүй, хариуцлага тооцох, төлбөрийн биелэлтийг албадан барагдуулах тогтолцоо бүрэн үйлчлэхгүй байгааг харуулж байна.

4.2.1.3 Төлөгдөөгүй торгуулийн дийлэнх хэсэг буюу 60 хувь (171.2 сая төгрөг) нь Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Автотээврийн тухай хууль зөрчсөн зөрчил байсан бол 29 хувь (83.0 сая төгрөг) нь олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явсан зөрчилтэй холбоотой байв.

4.2.1.4 Ногдуулсан торгуулийг төлж, барагдуулаагүй иргэдэд хуульд заасан дараагийн шатны арга хэмжээг авч, торгуулийн төлбөрийг төвлөрүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

4.2.1.5 Ногдуулсан торгуулийг биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан дараагийн шатны арга хэмжээ (жишээлбэл, албадан гүйцэтгүүлэх ажиллагаа) авч хэрэгжүүлээгүйгээс төлбөр барагдуулах үр дүн хангалтгүй байна. Жишээ нь, аймгийн ЗДТГ-ын уул уурхайн хяналтын улсын байцаагчийн 2024 онд ногдуулсан торгуулийн 40.0 сая төгрөгөөс зөвхөн ЭБЭ ХХК-нд хамаарах 20.0 сая төгрөгийн торгуулийг шүүхийн шийдвэрээр албадан гүйцэтгүүлэхээр болсон бол Эф Жи Пи Эм ХХК-тай холбоотой шийтгэлийг одоогоор шүүхэд шилжүүлсэн байна.

4.2.1.6 Иймд торгууль ногдуулсан шийдвэрийн биелэлтийг хянах, биелүүлээгүй тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна. Энэ нь төсвийн орлого бүрэн төвлөрөх нөхцөлийг хангаж, зөрчлийн эсрэг хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Г.2.2 Прокурорын байгууллагаас 2023, 2024 онуудад нийт 789 шийдвэрийн хуудсыг хүчингүй болгож, өөрчлөлт оруулсан байна.

4.2.2.1 Зөрчил шалган шийдвэрлэх ЭБАТ нь зөрчлийн хэрэг үүсгэсэн, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хуульчилсан. Иймд Прокурорын байгууллагаас зөрчлийн хэрэг бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэхдээ торгуулийн биелэлтийг хянадаг нь орлогын бүрдүүлэлтэд нөлөө үзүүлж байна.

Хүснэгт №9 Прокурорын байгууллагаас хүчингүй болгосон, өөрчлөлт оруулсан шийдвэрийн тоо

№	Байгууллагын нэр	Хүчингүй болгосон		Өөрчлөлт оруулсан		Дүн
		2023 он	2024 он	2023 он	2024 он	
1	Цагдаагийн газар	33	96	121	513	763
2	Хилийн цэргийн 0168 дугаар анги	7	-	2	-	9
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	1	-	-	-	1
4	Онцгой байдлын газар	-	-	1	-	1
5	Нийгмийн даатгалын газар	-	-	1	1	2
6	Байгаль орчны газар	-	-	1	1	2
7	Эм эмнэлгийн хэрэгслийн, хяналт зохицуулалтын газар	-	-	-	2	2
8	Хүнс, хөдөө аж ахуйн газар	-	-	-	3	3
9	Аймгийн Засаг даргын Тамгын газар	-	5	-	-	5
10	Авто тээврийн Үндэсний төвийн салбар	-	1	-	-	1
Нийт дүн		41	102	126	520	789

4.2.2.2 Тайлант онуудад Прокурорын байгууллагаас нийт 143 иргэн, аж ахуйн нэгжид ногдуулсан торгуулийн шийдвэрийн хуудсыг хүчингүй болгож, хуулийн зохицуулалтыг буруу хэрэглэсэн 646 шийдвэрийн хуудсанд өөрчлөлт оруулсан байна.

4.2.2.3 Хуулийн үндэслэлгүй шийдвэрүүд нь иргэд, аж ахуйн нэгжийн хувьд эдийн засгийн хохирол учруулах, төрийн шийдвэрт итгэх итгэлийг сулруулах, торгуулийн орлогын бүрдүүлэлт буурах зэрэг сөрөг үр дагавартай байна. Хүчингүй болгосон шийдвэрүүдийг дахин гаргуулахгүй байх талаар Прокурорын байгууллагаас холбогдох ЭБАТ-д албан мэдэгдэл хүргүүлж, торгууль төлсөн этгээдүүдэд төлбөрийг нь буцаан олгосон нь хүний эрхийг хамгаалах, хариуцлагыг оновчтой хүлээлгэхэд чухал ач холбогдолтой юм.

4.2.2.4 Түүнчлэн, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу торгууль ногдуулсан ЭБАТ-ууд шийдвэрийн биелэлтийг бүрэн хариуцах үүрэгтэй бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагууд болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны зүгээс хяналт, шалгалтын үйл

ажиллагаа хангалтгүй хэрэгжиж байгаа нь төсвийн зарцуулалтын ил тод байдал, үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

4.2.2.5 Иймд торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтнуудын хууль хэрэглээний мэдлэгийг сайжруулах, эрх зүйн хяналтыг тогтолцоотой хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг бүх шатанд үнэлэх, тайлагнах, хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Г.2.3 Торгуул ногдуулсан ЭБАТ торгуулийн орлогын биелэлтэд хяналт тавьж, хяналтыг хэрэгжүүлэхээр хуулийн зохицуулалттай байна.

4.2.3.1 Зөрчлийг хэрэг бүртгэлийг хянан удирдах ажилтнууд зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн эрх бүхий албан тушаалтанд даалгах, зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулах шаардлагатай бол хэрэг бүртгэлтийн хугацааг 14 хүртэл хоногоор сунгах, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх зэрэг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

4.2.3.2 Шийтгэлийн торгуулийн орлогыг тухайн шийдвэрийг ногдуулсан ЭБАТ бүрэн хариуцаж зөрчлийн биелэлтийн хуудсыг хэрэг бүртгэлд хавсаргадаг байна.

Г.2.4 Аудитын хамрах хугацаанд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

4.2.4.1 Аймгийн хэмжээнд торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудын хяналт хэрэгжээгүй нь ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах төрийн бодлогын хэрэгжилтийг сулруулж байна.

4.2.4.2 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2.6-д заасны дагуу олон нийтийн оролцоог хангах, төсвийн зарцуулалтад хөндлөнгийн хяналт бий болгох үүрэг хүлээсэн хэдий ч хяналтын механизм, оролцооны хэлбэр, хэрэгжүүлэх хариуцагчийг нарийвчлан тодорхойлоогүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

4.2.4.3 Энэ нь төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын үр нөлөөг бууруулж, иргэдийн итгэлцэл, хариуцлагын тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд олон нийтийн оролцоог бодитой хангах, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг журмаар тодорхой тусган, хэрэгжилтийг үнэлэх хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.

1. Хүү, торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, гэрээний нөхцөл, бодит суурь судалгаанд үндэслэлгүй, хэт өндрөөр төлөвлөсөн нь орлого тасрах, төсвийн орлого бүрэн төвлөрөхгүй байх нөхцөл бий болсон байна.
2. Нийгмийн даатгалын сангийн хүүгийн орлогыг төлөвлөх, баталгаажуулах ажиллагаа хуульд нийцэж байгаа боловч орон нутгийн өмчит байгууллагуудын хүүгийн орлогыг тогтмол төлөвлөхгүй, оновчтой удирдах тогтолцоо бүрдээгүй байна.
3. Орон нутгийн төсөвт төвлөрөх ёстой 291.3 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийг зөрчиж, орон нутгийн санхүүгийн бололцоог хязгаарласан зөрчил болж байна.
4. Торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой журмууд шинэчлэгдээгүй, эрх зүйн зохицуулалт хоорондоо зөрчилтэй байгаа нь хэрэгжилтэд тодорхой бус байдал үүсгэж байна.
5. Эрх бүхий албан тушаалтнууд торгуулийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хууль зөрчсөн тохиолдол цөөнгүй байж, прокурорын байгууллагаас олон тооны шийтгэврийн хуудсыг хүчингүй болгож, засвар оруулсан нь хяналтын тогтолцоо сул байгааг харуулж байна.
6. Цахим торгуульд иргэдээс гомдол гаргаагүй нөхцөлд хяналт тавих боломж хязгаарлагдмал байгаагаас үүдэн хууль тэгш үйлчлэх зарчим бүрэн хангагдахгүй байна.
7. Хугацаа хэтэрсэн торгуулийн төлбөрийг албадан төвлөрүүлэх хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгаа нь төлбөрийн сахилга бат алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.
8. Хүү, торгуулийн орлогоор санхүүжих зардлыг урьдчилан төлөвлөж, зориулалттайгаар зарцуулах санхүүгийн удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаагаас төсвийн хөрөнгийн үр ашиг буурч байна.
9. Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс тасрах эсвэл хэтрэх нөхцөлд шалтгаан, нөхцөлийг үнэлж дүгнэдэггүй нь дараагийн төлөвлөлт, санхүүгийн удирдлагад сөргөөр нөлөөлж байна.
10. Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, эрх зүйн зохицуулалтын уялдаа сул, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байгаа нь хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд системтэй доголдол үүсгэж, төсвийн орлогыг бууруулах, хууль зөрчих, иргэдийн эрх ашгийг хохироох эрсдэл дагуулж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн ИТХ-д:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах төсвийг Зөрчлийн торгуулийн орлогын 40 хувиас доошгүй хэмжээнд хуульд заасны дагуу төлөвлөж, хэвших
2. ГХЗУС тухай хуулийн 38.2.6-д заасны дагуу олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналтын механизмыг бүрдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсвийн зарцуулалтад ил тод, хариуцлагатай хяналт тавих тогтолцоо бүрдүүлэх

Аймгийн Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. Хуулийн хугацаанд торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, төлөгдөөгүй торгуулиудад дараагийн шатны арга хэмжээ авах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах
2. Хүү, торгуулийн орлогыг нэгдсэн цахим санг үүсгэж, бүртгэх, орлого төвлөрүүлэлтийн хяналтыг сайжруулах, төлбөр төлөлтийн дүнд хяналт тавих орчныг бий болгож ажиллах
3. Торгуулийн орлогыг тухайн онд шууд төлөвлөхөөс илүүтэйгээр өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн баталгаат хөрөнгө эх үүсвэр болгон тооцож, үр ашигтай, бодитой төлөвлөх
4. Хүү, торгуулийн орлогын урсгалд олон нийтийн оролцоог хангах тогтолцоог (тухайлбал, хөндлөнгийн хяналтын зөвлөл, цахим хяналтын самбар) бий болгож, зарцуулалтыг иргэдэд тайлагнадаг тогтмол үйл явцыг хэвшүүлэх

Аймгийн Цагдаагийн газарт:

1. Торгууль ногдуулах, төлбөр төвлөрүүлэх ажиллагааг сайжруулж, төлөгдөөгүй торгуулийн дүнг мэдээллийн урсгалаар хянах, торгуулийн үлдэгдлийг бүрэн төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн зарцуулалтад хяналт тавих чиг үүргийн хүрээнд 2025 оны гүйцэтгэл, 2026 оны онд хийх аудитын төлөвлөлтөд оруулж, хэрэгжүүлээгүй хяналт, шалгалтын ажлыг нэн даруй төлөвлөн гүйцэтгэх

Үндэсний аудитын газраар уламжлуулан холбогдох төр захиргааны төв байгууллагуудад хүргүүлж болохуйц дараах саналыг хүргүүлж байна. **Үүнд:**

- Хүү, торгуулийн орлого бүрдүүлсэн болон зарцуулсан талаарх мэдээллийг тодорхой төрөл ангиллаар, стандартын дагуу, цахимаар нээлттэй байршуулах үүрэг төрийн байгууллагад хүлээлгэх
- Торгуулийн төлбөрийг албадан гүйцэтгүүлэх ажиллагааны журам, шат дараалал, хугацаа, хариуцсан байгууллагын эрх үүргийг тодорхой болгох
- Хүү, торгуулийн орлогын анхан шатны бүртгэл, төвлөрүүлэлт, тайлагналт нь мэдээллийн нэгдсэн сангийн (ERP, BI систем) хүрээнд бүртгэгдэх эрх зүйн үндэс бий болгох
- Торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн биелэлтийг системтэй хянах, дүн шинжилгээ хийх хуулийн үүргийг тодорхой болгох
- Торгууль төлөөгүй тохиолдолд автомат сануулга, шүүхийн шат руу шилжих хугацааг тодорхой зааж, иргэдийн эрх зүйн итгэлцлийг хамгаалах

---oOo---

Холбогдох байгууллагын санал, тайлбар:


**МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас, факс: 70518232
Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn

2024.08.06 № 02/911
төний 2025.07.30-ны № 485 -Т

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаж дараах санал, тайлбарыг хүргүүлж байна.

Хүү, торгуулийн орлогыг төвлөрүүлэгч нэгж, албан хаагчид тухайн шийдвэрийн хуудсыг бүрэн төвлөрүүлэхэд ач холбогдол өгөхгүй, ажлын хоорондын уялдаа холбоо сул зэрэг олон шалтгаанаас орлогын гүйцэтгэл давах эсвэл тасрах эрсдэл үүсэж байна. Иймд аймгаас торгууль төвлөрүүлэгч нэгж, байгууллагатай хамтран тайланд жилийн шийдвэрийн хуудсыг торгуулийг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх зэрэг оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно.

**ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ**  **Б.БАТБААТАР**
2225080179

Шалгагдагч байгууллага тайлангийн төсөлтэй танилцаж, саналын зөрүүтэй санал ирүүлээгүй байна.

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газраас санал, тайлбарыг хуулийн хугацаанд ирүүлээгүй тул саналгүйд тооцов.

Аудитын тайланг баталгаажуулсан тушаал:



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/87

Баруун-Урт сум

**Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга, Цагдаагийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Ө.Золзаяа)-д үүрэг болгосугай.
3. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Ө.Золзаяа), аудитор (Г.Оюунболд), аудитор (Б.Мөнхбамбар), аудитор (О.Барчидгүнсэн) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА